

Говьсүмбэр аймаг дахь
Төрийн аудитын газар



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН БҮРДҮҮЛЭЛТ,
ЗАРЦУУЛАЛТ, ҮР НӨЛӨӨ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: ГСА-2022/30-5-ШТА-ГА

Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын
газрын дарга, тэргүүлэх аудитор:
Б.Сарантуяа, Утас: 70543156
Цахим хаяг: Sarantuyab@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Наранбаяр,
Утас: 70543179
Цахим хаяг: Naranbayarg@audit.gov.mn

Ахлах аудитор: Ц.Батсайхан, Утас: 70543179
Цахим хаяг: Batsaikhants@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу.
Цахим хуудас: www.audit.mn

<u>Тайланг бэлтгэсэн:</u> Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар Дарга, тэргүүлэх аудитор Б.Сарантуяа Аудитын менежер Г.Наранбаяр Ахлах аудитор Ц.Батсайхан Аудитор С.Батцэцэг Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70543156, 70543179 дугаарын утсаар харилцана уу. ХАЯГ: Сүмбэр сум 3-р баг, Нутгийн удирдлагын ордон, 205 тоот 2022 оны 6 дугаар сар	АГУУЛГА АГУУЛГА 2 ТОВЧИЛСОН ҮГС 3 Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтөд иргэдийн оролцоо хангалтгүй байна. 8 1.1 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн эх үүсвэрийг хууль, журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлсэн боловч санхүүжилтийг төсвийн хуваарийн дагуу олгоогүй байна. 8 1.2 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээг орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан төлөвлөсөн боловч иргэдийн саналыг хүртээмжтэй байдлаар аваагүй, санал авч эрэмбэлээгүй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг баталсан байна. 10 ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь орон нутгийн хөгжилд бодит үр дүнгээ үзүүлж байгаа боловч нийтийн эзэмшлийн хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт хангалтгүй байна. 14 2.1 Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөтөлбөр, төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхдээ худалдан авах ажиллагааг журмын дагуу зохион байгуулсан боловч сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна. 14 2.2. Ажлын хэсгүүд ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний төлөвлөсөн зорилтот түвшин, үр ашиг, үр дүнг бодитой тодорхойлоогүй боловч орон нутгийн хөгжилд бодит үр дүнг үзүүлж байна. 17 2.3 ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон нийтийн эзэмшлийн хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт хангалтгүй байна. 19 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн ажилд явцын хяналт хийгдээгүй байна. 20 3.1 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба, АИТХ, сумдын ИТХ-ын дэргэдэх хороо нь хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна. 20 3.2 ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтийн явцыг холбогдох заавар, журмын дагуу сум, аймгийн тайланг нэгтгэж, Сангийн яамд тайланг хүргүүлсэн байна. 22 Дүгнэлт Зөвлөмж Дээд шатны байгууллагад хүргүүлэх санал Шалгагдагч байгууллагын санал тайлбар Тайлан баталгаажуулах тушаал Тайлангийн хавсралтууд
--	---

ТОВЧИЛСОН ҮГС

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АИТХ	Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал
АМ	Ашигт малтмал
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
АОНХС	Аймгийн орон нутгийн хөгжлийн сан
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИНХ	Иргэдийн нийтийн хурал
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НАТ	Нөөц ашигласны төлбөр
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СХАА	Санхүүгийн хяналт аудитын алба
ТА	Тогтвортой амьжиргаа
ТАХ	Төсөл арга хэмжээ
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
УМС	Удирдлагын мэдээллийн систем
ХБТХОХ	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс
ХО	Хөрөнгө оруулалт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Аудит хийх
үндэслэл,
бүрэн эрх:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2021 оны 06 дугаар тогтоол, “Аудитын төлөвлөгөө батлах тухай” Монгол Улсын Ерөнхий аудиторов 2022 оны А/12 дугаар тушаал, Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу хийлээ.

Аудитын зорилт:

Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүнд Гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гарган холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн.

Аудитын зорилтыг хангахын тулд аудитыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэлээ. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг холбогдох хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх;
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг журмын дагуу үр дүн, үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх;
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг хууль, журмын дагуу хянаж, тайлагнасан эсэх;

Аудитад ашигласан
шалгуур үзүүлэлт:

Дараах хууль эрх зүйн актын холбогдох заалтуудыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

- ✓ Төсвийн тухай хууль
- ✓ Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль /2020 он/
- ✓ Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт;
- ✓ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль;
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- ✓ Монгол улсын Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал”
- ✓ Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”
- ✓ Сангийн сайдын 2018 оны 288 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”
- ✓ Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”
- ✓ Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”
- ✓ Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжүүд;
- ✓ Барилга, байгууламжийн батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, байгуулсан гэрээ болон бусад холбогдох эрх зүйн актууд.

Аудитын хамарсан
хүрээ:

Аудитын арга зүй:

Аудитад аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс, Орон нутгийн өмчийн газар, аймаг, сумдын ОНХС-гийн 2021 оны үйл ажиллагааг хамруулав.

Аудит хийх багийн
бүрэлдэхүүн,
хугацаа:

Аудитыг АДБОУС (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит”, MNS 6817-6:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит”-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан ТАБ-аас аудит хийх журам, түүнд нэмэлт өөрчлөлт оруулсан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/81 дүгээр тушаал, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/69 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ыг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулна.

Аудитыг дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа хянан удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр хэрэгжүүлж, ахлах аудитор Ц.Батсайхан, аудитор С.Батцэцэг нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Хүндрэл бэрхшээл:

Аудитын талбарын ажлыг 2022 оны 05 дугаар сарын 05-ны өдрөөс эхлүүлж, тайланг Тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулан шалгагдагч байгууллага болон холбогдох эрх бүхий албан тушаалтанд 2022 оны 06 дугаар сарын 13-ны өдөр хүргүүллээ.

Аудитыг гүйцэтгэх хугацаанд “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн” сэдэвт аудиттай аудитын хугацаа давхардсан, 1 орон тоо дутуу ажиллаж байгаагаас хүний нөөцийн дутагдал үүссэн нь аудитад хүндрэл учруулж байлаа.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

ОНХНС болон улсын төсвөөс аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн хэмжээг 2020.11.13-ны өдөр баталсан Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулийн 17 дугаар зүйлд зааснаар 1,513.6 сая төгрөгөөр баталсан байна.

Тус хуульд 2021 оны 07 дугаар сарын 07-ны өдөр оруулсан нэмэлт өөрчлөлтөөр ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн хэмжээг 44.4 сая төгрөгөөр нэмж, 1,558.0 сая төгрөгөөр баталсан байна.

Олон Улсын Хөгжлийн Ассоциаци болон Монгол Улсын Засгийн газар хооронд 2015 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр “Тогтвортой амьжиргаа 3” төслийг хэрэгжүүлэхээр Зээл №5487-MN тоот санхүүжилтийн хэлэлцээр хийсэн бөгөөд тус төсөл нь хөдөө орон нутагт тэргүүлэх ач холбогдол бүхий хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжүүлэхэд иргэдийн оролцоо, засаглалыг сайжруулах зорилготой үйл ажиллагаа явуулж байна.

Энэ хүрээнд Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулийн 4 дүгээр хавсралтаар Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөр буюу дээрх төслөөс 2021 онд 20.8 сая төгрөгийн дэмжлэг, 80.9 сая төгрөгийн урамшуулал олгохоор баталжээ.

Тайлант онд аймгийн ОНХС-д 1,162.7 сая, Сүмбэр сумын ОНХС-д 659.8 сая, Шивээговь сумын ОНХС-д 367.7 сая, Баянтал сумын ОНХС-д 82.3 сая, нийт 2,272.5 сая төгрөгийн төсөв баталсан байна. Үүнээс ОНХС-гаас 1,558.0 сая төгрөгийг, ОНХС-гийн эхний үлдэгдлээс 412.3 сая, өмнөх оны тэнцлийн ашгаас 302.2 сая төгрөгийг тус тус санхүүжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр бүрэн санхүүжүүлсэн байна.

Аймаг, сумдын ОНХС-гийн батлагдсан төсөв, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал

Д/д	Аймаг, сумдын нэр	Хүснэгт №1/сая.төг/		
		Баталсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү
1	Аймгийн ОНХС	1,162.7	968.9	193.8
2	Сүмбэр сумын ОНХС	659.8	520.0	139.8
3	Шивээговь сумын ОНХС	367.7	336.5	31.2
4	Баянтал сумын ОНХС	82.3	76.5	5.8
Нийт дүн		2,272.5	1,901.9	370.6

Хүснэгтээс харахад: тайлант хугацаанд нийт 370.6 сая төгрөг үлдэгдэлтэй байна. Үүнд:

- АОНХС нь хөтөлбөр, төсөл арга хэмжээний зардлыг 145.5 сая, хөрөнгийн зардлын 48.3 сая,
- Баянтал сумын ОНХС нь хөтөлбөр, төсөл арга хэмжээний зардлыг 3.0 сая, хөрөнгийн зардлын 2.8 сая,
- Сүмбэр сумын ОНХС нь хөтөлбөр, төсөл арга хэмжээний зардлыг 4.6 сая, хөрөнгийн зардлын 135.2 сая,
- Шивээговь сумын ОНХС нь хөтөлбөр, төсөл арга хэмжээний зардлыг 0.4 сая, хөрөнгийн зардлын 30.8 сая төгрөг тус тус байна.

Дүрслэл товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл арга хэмжээний эрэмбэлсэн жагсаалтад ороогүй ажлууд	12
Дүрслэл 2	Худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтын талаарх мэдээлэл	14
Дүрслэл 3	Үлдэгдэл санхүүжилтийн задаргааг аймаг, сумдаар	16
Дүрслэл 4	Хэрэгжээгүй 6 ажил	17
Дүрслэл 5	Үр дүнтэй байгаа ажлуудын жагсаалт	18
Дүрслэл 6	Үр дүнгүй болсон 4 ажлын жагсаалт	19
Дүрслэл 7	Захиалагчийн хяналт болон зохиогчийн хяналт хэрэгжүүлээгүй ажил	21
Дүрслэл 8	УМС-д холбогдох мэдээллийг бүрэн байршуулаагүй зөрчил	23

Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Аймаг, сумдын ОНХС-гийн батлагдсан төсөв, гүйцэтгэл	6
Хүснэгт 2	Орлогын шилжүүлгээс хуваарилах 1,558.0 сая төгрөгийн эх үүсвэрийн нэр, төрөл	8
Хүснэгт 3	ОНХНС болон аймгийн ОНХС-аас сумдад олгосон орлогын шилжүүлэг (сараар)	9
Хүснэгт 4	Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийн судалгаа	9
Хүснэгт 5	Багийн иргэдээс авсан ОНХС-ийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний саналын судалгаа	9
Хүснэгт 6	Аймгийн хэмжээнд 2021 онд ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан төсөл, арга хэмжээний мэдээлэл	11
Хүснэгт 7	ОНХС-гийн батлагдсан төсөв, гэрээ, гүйцэтгэл харьцуулсан судалгаа	15
Хүснэгт 8	ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр баталсан төсөл арга хэмжээний судалгаа	17

БҮЛЭГ 1

Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтөд иргэдийн оролцоо хангалтгүй байна.

1.1 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн эх үүсвэрийг хууль, журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлсэн боловч санхүүжилтийг төсвийн хуваарийн дагуу олгоогүй байна.

1.1.1 Хуульд заасан эх үүсвэр бүрээр сангийн эх үүсвэрийг бүрдүүлсэн байна.

Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-д Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан нь дараах эх үүсвэрээс бүрдэхээр заасан байна. Үүнд:

- Импортоос бусад бараа, ажил, үйлчилгээний нэмэгдсэн өртгийн албан татварын орлогын 5 хувь
- Газрын тосны нөөц ашигласны төлбөрийн орлогын 30 хувь
- Ашигт малтмалын тухай хуулийн 47.3 дугаар зүйлд зааснаас бусад ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогын 10 хувь
- Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн орлогын 50 хувь
- Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн орлогын 50 хувь
- Орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоодын төрийн бус байгууллагын болон гадаадын албан ёсны тусламж, хандив, дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг

Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар ОНХНС-аас Говьсүмбэр аймагт олгох орлогын шилжүүлэгт 1,513.6 сая төгрөг баталж, төсвийн тодотголоор 44.4 сая төгрөгөөр нэмж, нийт 1,558.0 сая төгрөгөөр баталсан байна. Хуульд заасан эх үүсвэр бүрээр сангийн эх үүсвэрийг бүрдүүлсэн байна.

1.1.2 Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг ОНХНС-аас Сангийн сайдын 2012 оны 32 дугаар тушаалаар баталсан аргачлалын дагуу тооцож хуваарилсан байна.

Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар ОНХНС-аас Говьсүмбэр аймагт нийт 1,558.0 сая төгрөгийн орлогын шилжүүлэг хуваарилахаар баталсан байна.

Сангийн яамнаас ОНХНС-гаас олгох орлогын шилжүүлгийн тооцооллыг Сангийн сайдын 2012 оны 32 дугаар тушаалаар баталсан аргачлалын дагуу боловсруулж, аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэст санхүүжилт олгох хуваарийн хамт ирүүлсэн байна.

Орлогын шилжүүлгээс хуваарилах 1,558.0 сая төгрөгийн эх үүсвэрийг нэр, төрлөөр нь харуулбал:

Хүснэгт №2 /сая.төг/

Дотоодын НӨАТ	Газрын тосны НАТ	АМНАТ	АМНАТ /Мега-гаас бусад/	АМ-ын тусгай зөвшөөрлийн төлбөр		ТА-3 төслөөс сумдын ОНХС-д олгох	
				ашиглалтын	хайгуулын	урамшуулал	дэмжлэг
260.5	48.4	525.5	445.0	153.6	23.4	80.9	20.7
16.7%	65.4%			11.4%		6.5%	

Хүснэгтээс харахад: аймагт олгох орлогын шилжүүлгийн нийт дүнд АМНАТ-ийн орлогоос 65.4 хувь, дотоодын НӨАТ-ын орлогоос 16.7 хувь, АМ тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогоос 11.4 хувь, ТА-3 төслөөс олгох урамшуулал дэмжлэг 6.5 хувийг эзэлж байна.

ОНХНС-гаас 1,558.0 сая төгрөгийн орлогын шилжүүлгийг аймгийн ОНХС-д 61.7 хувь буюу 961.1 сая төгрөг, сумдын ОНХС-д 38.3 хувь буюу 596.9 сая төгрөг хуваарилахаар төлөвлөж бүрэн олгосон байна.

1.1.3 Аймгийн ОНХС-аас сумын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг хуваарийн дагуу олгоогүй байна.

Аймгийн ОНХС-гаас нийт 596.9 сая төгрөгийн орлогын шилжүүлгийг сумдын ОНХС-д олгосон байна.

ОНХНС болон аймгийн ОНХС-аас сумдад олгосон орлогын шилжүүлгийг (сараар) хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №3 /Сая.төг/

Сар	ОНХНС			Сүмбэр			Баянтал			Шивээговь		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
2	39.5	19.7	19.8	5.1	5.1	-	1.3	1.3	-	3.9	3.9	-
3	63.3	39.7	23.6	9.4	9.4	-	2.5	2.5	-	7.1	7.1	-
4	203.3	61.5	141.8	25.3	9.0	16.3	4.1		4.1	39.9		39.9
5	180.8	254.3	- 73.5	62.2	78.5	- 16.3	17.3	21.4	- 4.1	45.9	85.8	- 39.9
6	63.3	-	63.3	9.4		9.4	2.5		2.5	7.1		7.1
7	234.4	65.5	168.9	28.7	53.4	- 24.8	4.4	14.2	- 9.8	47.6	37.1	10.6
8	63.3	469.1	- 405.9	9.4		9.4	2.5		2.5	7.1	24.8	- 17.7
9	63.3	114.2	- 50.9	9.4	3.5	5.9	2.5		2.5	7.1	7.1	-
10	470.1	161.6	308.5	64.2		64.2	8.1		8.1	98.6		98.6
11	85.9	251.9	-165.9	16.0	80.2	- 64.2	2.3	8.0	- 5.7	9.1	107.7	- 98.6
12	91.0	120.5	- 29.5	5.6	5.6	-	3.1	3.1	-	28.4	28.4	-
Нийт дүн	1,558.0	1,558.0	- 0.0	244.8	244.8	- 0.0	50.4	50.4	- 0.0	301.7	301.7	0.0

Хүснэгтээс харахад: Сангийн яам ОНХНС-гаас олгох орлогын шилжүүлгийг 2021 оны 04 сараас 11 дүгээр сар хүртэлх хугацаанд сарын хуваарийн дагуу санхүүжүүлээгүйгээс шалтгаалж, сумдын ОНХС-д орлогын шилжүүлгийг хуваарийн дагуу олгоогүй байна.

Санхүүжилт хуваарийн дагуу цаг хугацаандаа олгогдоогүй нь сангийн эх үүсвэрийг бүрдүүлж буй орлогын бүрдүүлэлттэй холбоотой байна.

1.1.4 Аймаг, сумдын ОНХС-д Төсвийн тухай хуульд заасны дагуу эх үүсвэрийн боломжийг судалж, орон нутгийн хөгжлийн санд нийт 714.5 сая төгрөг нэмж баталсан байна.

Аймаг, сумдын ОНХС-гийн эх үүсвэрийг Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.4¹-т заасны дагуу аймгийн ОНХС-д 20.0 сая, Сүмбэр сумын ОНХС-д 275.0 сая, Баянтал сумын ОНХС-д 7.2 сая төгрөгөөр, эхний үлдэгдлээс 412.3 сая, нийт 714.5 сая төгрөгийг тус тус нэмж баталсан байна.

¹ 60.2.4. татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон нэмэгдэл эх үүсвэр

Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийн судалгааг хүснэгтээр харуулбал (аймаг, сумдаар):

Хүснэгт №4 /Сая.төг/

№	ОНХС-ийн нэр	Эхний үлдэгдэл	ОНХНС-аас	Тэнцлийн ашиг	Нийт дүн
1	Аймгийн ОНХС	181.6	961.1	20.0	1,162.7
2	Сүмбэр сумын ОНХС	140.0	244.8	275.0	659.8
3	Баянтал сумын ОНХС	24.7	50.4	7.2	82.3
4	Шивээговь сумын ОНХС	66.0	301.7		367.7
	Нийт дүн	412.3	1,558.0	302.2	2,272.5

Хүснэгтээс харахад: ОНХС-гийн нийт эх үүсвэрийн 68.5%-ийг ОНХНС-аас олгох шилжүүлгийн орлого, 18.1%-ийг эхний үлдэгдэл санхүүжилтээс, 13.4%-ийг тэнцлийн ашгаас тус тус бүрдүүлсэн байна.

1.2 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээг орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан төлөвлөсөн боловч иргэдийн саналыг хүртээмжтэй байдлаар аваагүй, санал авч эрэмбэлээгүй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг баталсан байна.

1.2.1 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлтөд иргэдийн 19%-ийг хамруулсан нь иргэдийн оролцоо, санал хангалтгүй байгааг харуулж байна.

2021 оны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө аймгийн хэмжээнд 2,324 иргэнээс 313 санал авч эрэмбэлсэн байна. Тухайлбал: Аймгийн хэмжээнд санал өгөх боломжтой нийт 11,746 иргэдийн 19% нь санал өгчээ.

Багийн иргэдээс авсан ОНХС-ийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний саналын судалгааг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №5 /Сая.төг/

Сумын нэр	Санал авах		Санал авсан		Зөрүү		Төсөл арга хэмжээний саналын тоо
	Өрхийн тоо	Иргэдийн тоо	Өрхийн тоо	Иргэдийн тоо	Өрхийн тоо	Иргэдийн тоо	
Сүмбэр	3,682	8,537	1,226	1,226	2,456	7,311	143
Баянтал	340	739	237	248	103	491	25
Шивээговь	1,039	2,470	823	850	216	1,620	145
Нийт дүн	5,061	11,746	2,286	2,324	2,775	9,422	313

Хүснэгтээс харахад: ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээнд нийт өрхийн 45%, иргэдийн 19% нь санал өгсөн нь иргэдийн оролцоо хангалтгүй байгааг харуулж байна. Энэ нь ковид-19 цар тахалтай холбоотойгоор санал авахдаа иргэдийг хүртээмжтэй байдлаар хамруулж чадаагүй байна.

Нийт нэгтгэсэн саналд Сүмбэр сумын иргэдийн санал 45.7%, Шивээговь сумын иргэдийн санал 46.3%, Баянтал сум 8.0%-ийг эзэлж байна.

Баянтал сум иргэдээс ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний саналыг авахдаа санал авах хуудасны ард санхүүжүүлэх чиг үүргүүд, хориглох заалт зэрэг зөвлөмж

мэдээллийг хэвлэж иргэдэд тус сангийн хөрөнгийн зарцуулалтын талаарх мэдээлэл, чиглэл өгснөөр орон нутгийн бодлого чиглэлтэй уялдсан сайн жишээ болж цэгцтэй цөөн ажлын санал өгсөн байна.

Сумдад багийн дарга нар иргэдээс Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 1 дүгээр хавсралт дахь маягтаар ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг цаасаар болон цахимаар хүлээн авч нэгтгэн, багийн ИНХ-аар хэлэлцүүлсэн байна. Уг хурлаар ач холбогдол болон санал авсан тоогоор нь эрэмбэлж, багийн ИНХ-ын тогтоолоор батлан эрэмбэлсэн саналыг тус багийн Засаг даргад хүргүүлж ажилласан байна.

1.2.2 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө иргэдийн нийтийн хурлын эрэмбэлсэн жагсаалтад ороогүй 353.0 сая төгрөгийн 16 хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг баталсан байна.

Аймаг, сумдын ИТХ-ын тогтоолоор баталсан ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 100 төсөл, арга хэмжээ нь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, аймаг, сумдын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдсан боловч иргэдийн санал аваагүй, эрэмбэлсэн жагсаалтад ороогүй 16 төсөл, арга хэмжээг баталсан байна.

Аймгийн хэмжээнд 2021 онд ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан төсөл, арга хэмжээний мэдээллийг хүснэгтээр харуулбал

Хүснэгт №6 /сая төг/

№	Нэр	ИТХ-ын тогтоолын огноо, дугаар	Төсөл арга хэмжээний тоо	Төсөв /сая.төг/
1	Аймгийн ОНХС	2021.07.23, №05	39	1,162.7
2	Сүмбэр сумын ОНХС	2021.08.13, №03	23	659.8
3	Баянтал сумын ОНХС	2021.07.30, №03	10	82.3
4	Шивээговь сумын ОНХС	2021.08.10, №04	28	367.7
Нийт дүн			100	2,272.5

Хүснэгтээс харахад: аймгийн ОНХС-гаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний тоо нийт ажлын 39%, батлагдсан төсвийн төсвийн 51.2%-ийг эзэлж байна.

Аймаг, сумдын Засаг даргаас ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээний эрэмбэлсэн жагсаалтыг батлуулахаар ИТХ-д хүргүүлдэг бөгөөд ИТХ-ын тогтоолоор иргэдээс санал аваагүй, эрэмбэлээгүй 353.0 сая төгрөгийн 16 төсөл, арга хэмжээг баталсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.6², Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.1.2³ дахь заалтуудыг зөрчсөн байна.

Иймд аймаг, сумдын ИТХ-д иргэдээс санал аваагүй, эрэмбэлсэн жагсаалтад ороогүй төсөл, арга хэмжээг батлахгүй байх зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл арга хэмжээний эрэмбэлсэн жагсаалтад ороогүй ажлуудыг дүрслэлээр харуулбал:

² 60.3.6.орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ

³ 3.1.2.ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь тухайн орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх

Дүрслэл №1

Аймгийн ОНХС /4 төсөл, арга хэмжээ/	- Сүмбэр сумын 8 дугаар байрны гадна зогсоолд ус зайлуулах систем хийх ажил-6.0 сая - Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн дотуур байрны дээвэр засварын ажил-47.4 сая - Ерөнхий боловсролыг 3 дугаар сургуулийн дээвэр засварын ажил-23.3 сая - Нийтийн эзэмшлийн байрны подволын шугам сүлжээний шинэчлэлийн ажил 92.7 сая,
Сүмбэр сумын ОНХС /8 төсөл арга хэмжээ/	- Тэмээн жингийн цуваа хөшөө баримал хийх ажил- 10.0 сая 1 дүгээр багийн дан байрнуудын цэвэр бохир усны шугам татах ажил-19.9 сая, - Иргэний танхимд тоног төхөөрөмж худалдан авах ажил / Суудлын автомашин/-20.0 сая - Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн гал тогооны тоног төхөөрөмж шинэчлэх ажил-25.0 сая - Сүмбэр сумын ЗДТГ-ын гадна тохижилтын ажил -20.0 сая - Сумын өвс тэжээл худалдан авах -10.0 сая 1 дүгээр багийн 133 дугаар байрны дээврийн засварын ажил -15.0 сая, - Сүмбэр суманд ашиглагдаж байгаа хяналтын камерыг засварлах -7.5 сая
Баянтал сумын ОНХС 2 төсөл арга хэмжээ	- Иргэдэд үйлчлэх нэг цэгийн үйлчилгээний төв байгуулах ажил-19.2 сая 2022 онд хийгдэх хөрөнгө оруулалтын ажлын зураг төсөв ажил-4.0 сая
Шивээговь сумын ОНХС 2 төсөл арга хэмжээ	- Цагдаагийн эргүүлийн автомашин-18.0 сая - Усан хангамжийн системийг алсын горимд оруулах ажил-15.0 сая

1.2.3 Сүмбэр, Шивээговь сумын ОНХС-аас тухайн шатны Засаг даргын чиг үүрэгт хамаарах 68.0 сая төгрөгийн 4 төсөл, арга хэмжээг тусгасан байна.

Тухайн шатны Засаг даргын чиг үүрэгт хамаарах хөрөнгө оруулалтын 68.0 сая төгрөгийн 4 ажлыг сумдын ОНХС-аар хэрэгжүүлэхээр баталсан байна. Үүнд:

1. Шивээговь сумын ОНХС-гаас сумын Цагдаагийн тасагт эргүүлийн автомашин -18.0 сая,
2. Сүмбэр сумын ОНХС-гаас Тэмээн жингийн цуваа хөшөө баримал хийх ажил- 10.0 сая, Иргэний танхимд тоног төхөөрөмж худалдан авах ажил /Суудлын автомашин/-20.0 сая, Сүмбэр сумын ЗДТГ-ын гадна тохижилтын ажил -20.0 сая

Энэ нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.4⁴, 60.4⁵, Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.2⁶, 4.2.3⁷ дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд ОНХС-аас тухайн шатны Засаг даргын чиг үүрэгт хамаарах төсөл, арга хэмжээг батлахгүй байх зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

1.2.4 Аймаг, сумын түвшинд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлтийн үйл явц дахь иргэдийн оролцоо хангалтгүй байна

Аймгийн Засаг даргын 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн А/79 дугаартай захирамжаар “Аймгийн эдийн засаг, нийгмийг 2021 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, орон нутгийн төсвөөр 2021

⁴ 60.3.4.нийтийн эрх ашигт нийцээгүй үйл ажиллагаа

⁵ 60.4.Энэ хуулийн 60.3.1-д заасан хуулиар тогтоосон чиг үүрэгт аймаг, нийслэл, сум, дүүргийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэг хамаарахгүй.

⁶ 4.2.2. Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.4-д заасан зүйлс

⁷ 4.2.3. Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.11-д зааснаас бусад төрлийн үйлчилгээний зардал

онд хэрэгжүүлэх хөрөнгө, оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний жагсаалт”-ыг боловсруулах ажлын хэсгийг томилсон байна.

Уг ажлын хэсгийн чиг үүрэгт 2021 онд аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний эрэмбэлсэн жагсаалтыг боловсруулах ажил тусгагдсан боловч бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна. Тухайлбал: журамд заасан хугацаанд (07 дугаар сард багтаан) 2 удаагийн нээлттэй хэлэлцүүлэг хийгээгүй, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар (08 дугаар сарын 10-ны дотор) төсөл, арга хэмжээний нэгдсэн жагсаалтыг хэлэлцүүлээгүй байна.

Аймаг, сумын иргэдтэй 2021.09.23-наас 25-ны өдрүүдэд нээлттэй хэлэлцүүлэг хийсэн байна.

Сүмбэр сумын хувьд ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний саналыг нэгтгэн эрэмбэлж, төлөвлөх зорилго бүхий ажлын хэсгийг томилсон шийдвэр, хийсэн ажлын тайлан, эрэмбэлсэн санал зэрэг шаардлагатай баримт материалыг аудитын явцад гаргаж ирүүлээгүй тул хэрхэн төлөвлөсөн нь тодорхойгүй байна.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.3⁸, Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 6 дугаар зүйлийн 6.1⁹, 6.2¹⁰, 6.3¹¹, 6.4¹², 7 дугаар зүйлийн 7.5¹³, 7.6¹⁴, 7.7¹⁵, 7.8¹⁶ дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд ажлын хэсэг томилсон шийдвэрийн хэрэгжилтийг хангуулж, ажлын хэсгийн үйл ажиллагаанд хяналт тавих тухай зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

⁸ 63.3. Энэ хуулийн 63.2-т заасны дагуу баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлаас ирүүлсэн саналыг сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар ач холбогдол, тухайн орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан эрэмбэлж, төсвийн төсөлд тусган сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ.

⁹ 6.1. Сум, дүүргийн Засаг дарга нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний саналыг нэгтгэн эрэмбэлж, төлөвлөх зорилго бүхий ажлын хэсгийг жил бүрийн I дүгээр улиралд багтаан сум, дүүргийн Засаг даргын захирамжаар байгуулна

¹⁰ 6.2. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн нь орон нутгийн хөдөө аж ахуй, байгаль орчны асуудал хариуцсан ажилтан, төрийн сангийн мэргэжилтэн, иргэд, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл болон бусад мэргэжилтнүүдийг багтаасан 7-оос доошгүй гишүүнтэй байна.

¹¹ 6.3. Ажлын хэсэг нь энэ журмын 5.13-т заасан баг, хорооны ИНХ-аас ирүүлсэн тогтоолоор батлагдсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг эрэмбэлэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ бүрийг хэлэлцэж, дараагийн төсвийн жилд хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтыг жил бүрийн 6 дугаар сард багтаан боловсруулна.

¹² 6.4. Ажлын хэсэг нь баг, хороодоос ирсэн саналыг нэгтгэж эрэмбэлэхдээ дараах үзүүлэлтүүдийг харгалзан зөвлөмж, дүгнэлт гарган сум, дүүргийн Засаг даргад хүргүүлнэ.

¹³ 7.5. Урьдчилсан жагсаалтыг аймаг, нийслэлийн Иргэний танхимаар дамжуулан нийтэд зар мэдээ хүргэсний үндсэн дээр нээлттэй хэлэлцүүлгийг 7 дугаар сард багтаан 2-оос доошгүй удаа зохион байгуулна

¹⁴ 7.6. Аймаг, нийслэлийн Засаг дарга иргэд, иргэний нийгмийн байгууллагаас хамгийн олон санал авсан, ажлын хэсгийн санал, дүгнэлтээр баталгаажсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний саналыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан танилцуулна.

¹⁵ 7.7. Ажлын хэсэг хэлэлцүүлгийн үр дүнг нэгтгэн аймаг, нийслэлийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний нэгдсэн жагсаалтыг 8 дугаар сарын 10-ны өдрийн дотор Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.

¹⁶ 7.8. Аймаг, нийслэлийн Засаг дарга нь Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцсэн нэгдсэн жагсаалтыг хурлын тэмдэглэл болон орон нутгийн төсвийн төсөлд тусган аймаг, нийслэлийн ИТХ-аар хэлэлцүүлэхээр хүргүүлнэ

БҮЛЭГ 2

ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь орон нутгийн хөгжилд бодит үр дүнгээ үзүүлж байгаа боловч нийтийн эзэмшлийн хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт хангалтгүй байна.


2.1 Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөтөлбөр, төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхдээ худалдан авах ажиллагааг журмын дагуу зохион байгуулсан боловч сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

2.1.1 Зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалтад холбогдох журмыг баримтлаагүй байна.

Хөрөнгө оруулалтын шинж чанартай 28 ажлаас 27 ажлын худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг 100% цахимаар зохион байгуулж, 1 ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй байна.

Худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтын талаарх мэдээллийг дүрслэлээр харуулбал:

Дүрслэл №3



Дүрслэлээс харахад: Нийт ажлын 62.9% буюу 17 ажлын гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулсан байна.

Аудитаар ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын шинж чанартай ажлуудын худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан эсэхэд тулган баталгаажуулалт хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнийг дэлгэрүүлбэл:

1. Сүмбэр сумын ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлэх 1 ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй, он дамжсан байна. Энэ нь 50.0 сая төгрөгийн өртөгтэй 1 ажлын (“Тудамж талбайн гэрэлтүүлгийн нэмэх, сайжруулах”) техникийн нөхцөлийг эрх бүхий байгууллагаас олгоогүйгээс шалтгаалсан байна.
2. Аймгийн ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх 22.0 сая төгрөгийн өртөгтэй зураг төсвийн ажлыг тендер шалгаруулалт нь 2 удаа хүчингүй болсон шалтгаанаар захиалагч хураангуй жагсаалтад ороогүй ажлыг шууд гэрээ байгуулсан байна.

Эдгээр нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.7¹⁷, 45 дугаар зүйлийн 45.1.¹⁸, 46 дугаар зүйлийн 46.1.4¹⁹, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3 дугаар зүйлийн 3.4.3²⁰, 3.4.4²¹ дэх гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Цаашид худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулж ажиллах зөвлөмжийг аймгийн ОНХС, Сүмбэр сумын ОНХС хариуцсан албан тушаалтнуудад өгөхөөр шийдвэрлэв.

2.1.2 ОНХС-гийн 132.0 сая төгрөгийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна.

Аймаг, сумдын ОНХС-гийн хөрөнгөөр 2021 онд санхүүжүүлэх 2,272.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 100 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 1,483.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын гэрээ байгуулж, гүйцэтгэлээр 1,901.9 сая төгрөгийн санхүүжилт олгосон ба 124.9 сая төгрөгийн 6 төсөл, арга хэмжээг огт хэрэгжүүлээгүй байна.

ОНХС-гийн 2021 оны батлагдсан төсөв, гэрээний дүн, гүйцэтгэлийг харьцуулсан судалгааг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №7 /сая.төг/

Сангийн нэр	Батлагдсан төсөв	Гэрээний дүн	Олгосон санхүүжилт	Үлдэгдэл		
				Хэмнэлт	Үлдэгдэл санхүүжилт	Огт хэрэгжээгүй ажил
Хөрөнгө оруулалтын шинж чанартай ажил						
Аймаг	609.3	599.6	635.0	18,2	36.1	
Сүмбэр сум	561.5	446.5	426.3	20.3	0.0	114.9
Баянтал сум	56.5	54.5	54.5	7.4	0.6	
Шивээговь сум	316.7	309.3	286.7	2.0	22.4	
ХО-ын дүн	1,544.0	1,409.9	1,402.5	47.8	59.1	114.9
Төсөл арга хэмжээ						
Аймаг	553.4	74.0	333.9	135.5		10.0
Сүмбэр сум	98.4		93.8	4.6		
Баянтал сум	51.0		49.8	1.4		
Шивээговь сум	25.7		21.9	3.3		
ТАХ-ний дүн	728.5		499.4	138.8		
НИЙТ ДҮН	2,272.5	1,483.9	1,901.9	186.6	59.1	124.9

Хүснэгтээс харахад: аймаг, сумдын ОНХС-гийн нийт төсвийг олгосон санхүүжилтийн дүнтэй харьцуулахад 83.7 хувийн гүйцэтгэлтэй байна.

Аймаг, сумдын ОНХС нь 2021 оны жилийн эцэст нийт 373.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа бөгөөд үүнээс гэрээ болон хөтөлбөр, төсөл арга хэмжээний хэмнэлт 186.6 сая, санхүүжилтийн үлдэгдэл 59.1 сая, огт хэрэгжээгүй ажлын төсөвт өртөг 124.9 сая төгрөг байна.

¹⁷ 36.7. Дэлгэрэнгүй жагсаалтад хамрагдсан зөвлөхүүдээс энэ хуулийн 14-16 дугаар зүйлийн шаардлага болон захиалагчаас тогтоосон чадавхийн үзүүлэлтийг хангасан 3 ба түүнээс дээш зөвлөхийг захиалагч сонгож, хураангуй жагсаалт гаргана.

¹⁸ 45.1. Улсын болон орон нутгийн төсвөөс хөрөнгө оруулалтаас бусад зардалд хуваарилсан хөрөнгө, бусад эх үүсвэр, түүнчлэн өөрийн хөрөнгөөр санхүүжигдэх бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг захиалагч энэ хуульд заасан журмын дагуу зохион байгуулах

¹⁹ 46.1.4. худалдан авах бараа, ажил, үйлчилгээг батлагдсан төсөвт багтаан үр ашигтай төлөвлөж, зохион байгуулах

²⁰ 3.4.3. “Сум, дүүргийн хэмжээнд ОНХС-ийн үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих”

²¹ 3.4.4. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээг худалдан авах гэрээг холбогдох хууль, аргачлал, журамд нийцүүлэн хийх, худалдан авах ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих”

Үлдэгдэл санхүүжилтийн задаргааг аймаг, сумдаар нь дүрслэлээр харуулбал:

Дүрслэл №4



Дүрслэлээс харахад: Үлдэгдэл санхүүжилтийн хувьд аймгийн ОНХС-гийн 11 ажлын санхүүжилтийн үлдэгдэл 52%-ийг эзэлж байна.

Тайлант хугацаанд ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний зарцуулалтыг тулган баталгаажуулахад нийт 132.0 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулаагүй дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Тэмцээн уралдаан, шагнал урамшууллын зардалд 85.1 сая төгрөг (Аймгийн ОНХС-гаас 11 хөтөлбөрийн хүрээнд 75.8 сая, Сүмбэр сумын ОНХС-гийн 1 хөтөлбөрөөс 9.3 сая) зарцуулсан
2. Иргэний танхимд тоног төхөөрөмж худалдан авах нэрээр 36.9 сая төгрөгөөр 2 суудлын автомашин худалдан авсан (Сүмбэр сумын ОНХС-гаас 19.4 сая, Шивээговь сумын ОНХС-гаас 17.5 сая)
3. Тэмээн жингийн цуваа хөшөө баримтал хийх- 10.0 сая /Сүмбэр ОНХС/



Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5²² 60 дугаар зүйлийн 60.3.4²³, 60.3.6²⁴, 60.4²⁵, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.3.2²⁶, 4.7.3²⁷, 4.7.5²⁸, 4.7.6²⁹ заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд аймгийн болон Сүмбэр, Шивээговь сумдад ОНХС-гийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулахгүй байх тухай албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

²² 16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;

²³ 60.3.4.нийтийн эрх ашигт нийцээгүй үйл ажиллагаа;

²⁴ 60.3.6.орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ.

²⁵ Энэ хуулийн 60.3.1-д заасан хуулиар тогтоосон чиг үүрэгт аймаг, нийслэл, сум, дүүргийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэг хамаарахгүй.

²⁶ 4.3.2.ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь тухайн орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх;

²⁷ 4.7.3.Нийтийн эрх ашигт нийцээгүй үйл ажиллагаа

²⁸ 4.7.5.Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ;

²⁹ 4.7.6.Аливаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд олгох буцалтгүй тусламж, дэмжлэг, тэтгэмж, урамшуулал.

²⁹ 4.7.6.Аливаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд олгох буцалтгүй тусламж, дэмжлэг, тэтгэмж, урамшуулал

2.2. Ажлын хэсгүүд ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний төлөвлөсөн зорилтот түвшин, үр ашиг, үр дүнг бодитой тодорхойлоогүй боловч орон нутгийн хөгжилд бодит үр дүнг үзүүлж байна.

2.2.1. Ажлын хэсгүүд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний төлөвлөсөн зорилтот түвшин, үр ашиг, үр дүнг бодитой тодорхойлоогүй байна.

Аймаг, сумдын ОНХС-гийн ажлын хэсэг нь багаас авсан саналыг нэгтгэж эрэмбэлэхдээ үр ашгийн тооцоолол (урьдчилан тооцсон төсөвт өртгийг үр өгөөж хүртэгчдийн тоонд харьцуулах) хийгээгүй байна.

Аймгийн хэмжээнд ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр 100 төсөл, арга хэмжээг баталсан бөгөөд 1,544.0 сая төгрөг буюу 67.9% нь хөрөнгө оруулалтын шинж чанартай ажил, 728.5 сая төгрөг буюу 32.1% нь хөтөлбөр, төсөл арга хэмжээ байна.

ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр баталсан төсөл арга хэмжээний судалгааг хүснэгтээр (аймаг, сумдаар) харуулбал:

Хүснэгт №8

Сангийн нэр	Тоо	Батлагдсан төсөв	Хөрөнгө оруулалтын ажил		Төсөл, арга хэмжээ	
			Тоо	Батлагдсан төсөв	Тоо	Батлагдсан төсөв
Аймаг	39	1,162.7	17	609.3	22	553.4
Сүмбэр сум	23	659.8	17	561.5	6	98.4
Шивээговь сум	10	367.7	21	316.7	7	51.0
Баянтал сум	28	82.3	6	56.5	4	25.7
НИЙТ ДҮН	100	2,272.5	61	1,544.0	39	728.5

Дүрслэлээс харахад: ОНХС-ийн хөрөнгийг хөрөнгө оруулалтын шинж чанартай ажилд аймгийн ОНХС 52.4%, Сүмбэр сум 85.1%, Шивээговь сум 86.1 %, Баянтал сум 68.6%-ийг тус тус зарцуулсан байна. Үүнээс харахад: аймгийн ОНХС нь төсөл арга хэмжээний зардал нийт хөрөнгийн 47.6%-ийг зарцуулж байгаад анхаарч цаашид төсөл арга, хэмжээний зардлыг бууруулж, хөрөнгө оруулалтын шинж чанартай ажилд түлхүү зарцуулах шаардлагатай байна.

Аймгийн хэмжээнд ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн ажлуудаас гэрээний хугацаанд хүлээж аваагүй болон огт хэрэгжээгүй нийт 206.9 сая төгрөгийн 7 ажил байна. Үүнд:

1. Тайлант онд төлөвлөсөн 124.9 сая төгрөгийн 6 ажил огт хийгдээгүй
2. Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлсэн 82.0 сая төгрөгийн 4 зураг төсөв боловсруулах ажлын гэрээний хугацаа дууссан байхад хугацаанд нь хүлээж аваагүй

Хэрэгжээгүй 6 ажлыг дүрслэлээр харуулбал:

Аймгийн ОНХС		Дүрслэл №5
•“Нэг өрх, нэг ажлын байр” төсөл арга хэмжээ 10.0 сая		
Сүмбэр сумын ОНХС		
•“Гудамж талбайд гэрэлтүүлэг нэмэх, сайжруулах” ажлын 50.0 сая		
•“Нэгдүгээр багийн дан байрнуудын цэвэр бохир усны шугам татах” ажлын 19.9 сая		
•“1 дүгээр багийн 133 дугаар байрны дээвэр засвар” ажлын 10 сая		
•“1, 5 дугаар цэцэрлэгийн гадна фасадын их засвар, 118 дугаар байрны техникийн давхрын засвар” ажлын 15.0 сая		
•“Сүмбэр сумын гадна тохижилт” ажлын 20.0 сая		

Сүмбэр сум нь эрх бүхий байгууллагаас техникийн нөхцөлийг аваагүй, төсөв өртгийг үнэн зөв тооцож төлөвлөөгүй ажлуудыг ОНХС-гаас санхүүжүүлэхээр баталснаас шалтгаалан 114.9 сая төгрөгийн 5 ажил хэрэгжээгүй нь тухайн жилийн зорилтот түвшинг хангаагүй, үр ашиг, үр дүнг бууруулсан байна.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4³⁰, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.3.3³¹ гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд ажлын хэсэг урьдчилан тооцсон төсөвт өртгийг үр өгөөж хүртэгчдийн тоонд харьцуулах замаар үр ашгийн тооцоолол хийх тухай зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.


2.2.2 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь орон нутгийн хөгжилд бодит үр дүн үзүүлж байна.

Аймаг, сумын ОНХС-ын хөрөнгөөр хийгдсэн ажлууд нь иргэдийн хэрэгцээ шаардлага болон үр дүн, ашиглалтын шаардлага хангасан эсэхэд үнэлэлт дүгнэлт өглөө.

Орон нутгийн хэмжээнд дараах 7 чиглэлийн ажил иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, цаг үеэ олсон, орон нутгийн хөгжилд үр дүнгээ өгсөн байна.

Иймд үр дүнтэй байгаа ажлуудын жагсаалтыг дүрслэлээр харуулбал:

Дүрслэл №6



ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлсэн дээрх ажлуудаас иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, цаг үеэ олсон, орон нутгийн хөгжилд үр дүнгээ өгсөн, сайн жишээ болсон ажлыг онцолбол: Нийтийн эзэмшлийн орон сууцнуудын орцны хаалгыг кодтой хаалгаар солих ажил хийгдсэн бөгөөд үүнийг иргэдийн оролцоотойгоор орцны хаалганы үнэ болон бусад зардлын 50%-ийг иргэдээс, 50%-ийг ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлж хэрэгжүүлсэн нь иргэдийн ая тухтай амьдрах орчин нөхцөлийг сайжруулсан, ашиглалт, хадгалалт, хамгаалалтын хувьд бусад ажлуудаас илүү үр дүнтэй болсон байна.

³⁰ 29.4.Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

³¹ 4.3.3 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, бусад холбогдох зөвшөөрөлтэй байх

2.3 ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон нийтийн эзэмшлийн хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт хангалтгүй байна.

2.3.1. ОНХС-ийн сангийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудын ашиглалтыг сайжруулж, хэвийн ажиллагааг хангаж ажиллах шаардлагатай байна.

Аймгийн хэмжээнд 2019-2021 оны хооронд ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлсэн 443.3 сая төгрөгийн өртөгтэй дараах 4 чиглэлийн ажил ашиглалтын шаардлага хангахгүй болсон байна. Ашиглалтын шаардлага хангахгүй болсон хэвийн ажиллахгүй байгаа эдгээр ажлуудын засвар үйлчилгээг хариуцах эзэн холбогдогч нь тодорхойгүй, засвар үйлчилгээний зардал байхгүй, зардлыг бодитой тооцоолоогүй байна.

Дүрслэл №7



Нийтийн эзэмшил дэх тоглоомын талбайн тохижилт, орон сууцнуудын дунд байрлах хог ангиан ялгах савнуудын ашиглалт зэрэг нь иргэдийн хариуцлагагүй байдал, хариуцагч байгууллагын ашиглалтад тавих хяналт дутмаг байдлаас хөрөнгө оруулалтын үр дүн буурсан байна. Тухайлбал:

- Аймаг, сумдын төвийн камержуулалт – аймгийн Цагдаагийн хэлтэс болон сумдын цагдаагийн тасагт хариуцуулж өгсөн талбайн камерууд нь ашиглагч байгууллагад засвар үйлчилгээний зардал төлөвлөөгүй, засвар үйлчилгээг хариуцах мэргэжлийн байгууллага байхгүй, камерын тусгал болон нягтаршил муу, интернэтэд бүрэн холбогдоогүй, тогтмол засвар үйлчилгээ хийгээгүй зэргээс байнга эвдрэл гарч, хэвийн ажиллахгүй байгаа
- Авто замын арчилгааны машин – “Тохижилт-Сүмбэр” ОНӨААТҮГ нь ашиглалтын шаардлага хангаагүй гэсэн шалтгаанаар автомашиныг ажиллуулаагүй, хөрөнгө ашиглалтгүй агуулахад хадгалагдаж байна.
- Нийтийн эзэмшлийн тоглоомын талбайн тохижилтын ажил – засвар үйлчилгээний зардлыг бодитой тооцоогүй, хариуцагч байгууллага засвар үйлчилгээ хийхгүй байгаагаас эвдэрч, муудсан



- Нийтийн эзэмшлийн орон сууцуудын дунд хог ангиан ялгах сав байршуулах ажил –Нийтийн эзэмшил дэх тоглоомын талбайн тохижилт, орон сууцуудын дунд байрлуулсан хог ангиан ялгах савнуудыг техникийн тодорхойлолтод заасан стандартаар хүлээж аваагүй, ашиглалт, хадгалалт, хамгаалалт муу, иргэдийн хариуцлагагүй байдал зэргээс эвдэрсэн байна.

Эдгээр нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1³², Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3³³, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.12³⁴ гэснийг тус тус зөрчсөн байна.

Цаашид, ОНХС-ийн сангийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудын засвар үйлчилгээний зардлыг бодитой төлөвлөж, батлуулах, ашиглалтыг сайжруулж, хэвийн ажиллагааг хангах албан шаардлагыг өгөв.

2.3.2 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон нийтийн эзэмшлийн хөрөнгөөс бусад хөрөнгүүдийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт хэвийн байна.

ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон нийтийн эзэмшлийн хөрөнгөөс бусад хөрөнгүүдийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт хэвийн байна.

Харин аймаг, сумдын ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлсэн нийтийн эзэмшлийн хөрөнгө оруулалтын ажлуудыг хүлээн авсан байгууллагуудад тухайн хөрөнгийн урсгал зардал, засвар үйлчилгээг хийх төсөв хөрөнгийг баталдаггүй, урсгал зардлыг бодит тооцооллын дагуу бүрэн олгохгүй байгаагаас шалтгаалан хөрөнгийн хадгалалт, хамгаалалт хангалтгүй байна.

БҮЛЭГ 3

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн ажилд явцын хяналт хийгдээгүй байна.

3.1 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба, АИТХ, сумдын ИТХ-ын дэргэдэх хороо нь хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.1.1 Аймаг, сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт, хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд тавих хяналт хангалтгүй байна.

Аймаг, сумдын ОНХС-гийн 2021 оны үйл ажиллагаанд аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

Аймгийн ИТХ-аас “2021 оны улсын болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад хяналт шалгалт хийх үүрэг бүхий ажлын хэсгийг” 2021 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 18 дугаар тогтоолоор 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна.

Уг ажлын хэсэг нь хяналтыг хэрэгжүүлсэн гэх боловч ажлын тайландаа хэдэн ажлыг шалгасан болон илрүүлсэн зөрчил дутагдал, өгсөн чиглэл зэргийг тусгаагүй, хийсэн ажил нь тодорхойгүй бөгөөд нэмэлт тодруулга авахад аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэж буй ажлуудын явцтай

³² Өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах

³³ 14.2.3.өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах;

³⁴ 9.12.ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон барилга байгууламж, тоног төхөөрөмж, эд хөрөнгийг хуульд заасны дагуу өмчлөлд бүртгэж авсан байгууллага нь ашиглалт, хадгалалт, хамгаалалтын зардлыг хариуцна.

танилцаж зөрчил дутагдалтай ажлуудыг сайжруулах талаар амаар чиглэл өгч ажилласан гэсэн тайлбар өгсөн

Шивээговь сумын ИТХ-ын дэргэдэх хороо нь сумын ОНХС-гийн 5 ажилд хяналт тавьж ажилласан бөгөөд “3 дугаар цэцэрлэгийн тоног төхөөрөмж” худалдан авах ажилд зөрчил илрүүлж, техникийн тодорхойлолтод заасны дагуу аяга, таваг угаагч ирээгүй байсан тул хүлээн авах ажлыг зогсож, техникийн тодорхойлолтод заасны дагуу тоног төхөөрөмж ирүүлсэн тохиолдолд хүлээн авахаар шийдвэрлэсэн байна.

Сүмбэр, Баянтал сумдын ИТХ-ын дэргэдэх хороо нь сумдын ОНХС-гийн 2021 оны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээгүй бөгөөд энэ тухай ярилцлагын тэмдэглэлээр баталгаажууллаа.


Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.1³⁵, 69 дүгээр зүйлийн 69.1³⁶, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.4³⁷, заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд аймаг, сумдын ИТХ болон аймгийн СХАА нь чиг үүргийн дагуу ОНХС-гийн үйл ажиллагаанд хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх тухай зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

3.1.2 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн 6 ажилд зохиогчийн хяналт, 1 ажилд захиалагчийн хяналтыг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Аймгийн хэмжээнд ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлсэн 94 төсөл, арга хэмжээнээс хөрөнгө оруулалтын 1 ажилд захиалагчийн хяналт, зураг төсвийн 6 ажилд зохиогчийн хяналтыг тус тус хэрэгжүүлээгүй бөгөөд бусад ажлуудад зохих хяналтуудыг хэрэгжүүлж ажилласан байна. Тухайлбал: Аймгийн ОНХС-гийн 3, Сүмбэр сумын ОНХС-гийн 3 ажилд зохиогчийн хяналт, Сүмбэр сумын 1 ажилд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Дүрслэл №8



Эдгээр нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6³⁸, Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх,

³⁵ 64.1.1.Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэлэлцэн батлах, хэрэгжилтэд хяналт тавих

³⁶ 69.1.Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна

³⁷ 9.4.ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэл болон энэ журмын хэрэгжилтэд төв, орон нутгийн хууль, хяналт, дотоод ба хөндлөнгийн аудитын байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын дэргэдэх хороо болон иргэд, иргэний нийгмийн байгууллагууд Төрийн аудитын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2015 оны “Дүрэм батлах тухай” 483 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Дотоод аудитын дүрэм” болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжид заасан чиг үүргийн дагуу хяналт тавина.

³⁸ 46.1.6.Гүйцэтгэгчийн гэрээний үүргийн биелэлтэд чанар болон гүйцэтгэлийн хяналт тавьж, явцын мэдээллийг хагас жил тутам худалдан авах ажиллагааны цахим системд оруулах

санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.4³⁹, 15 дугаар зүйлийн 15.3⁴⁰ дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

3.1.3 Өмнөх онд хийгдсэн нийцлийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлж ажилласан байна.

2020 онд УАГ-ын нэгдсэн удирдамжаар ОНХС-гийн 2019 оны орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүнд хийсэн аудитаар нийт 500.4 сая төгрөгийн зөрчил илрүүлж 301.0 сая төгрөгийн 6 албан шаардлага, 199.4 сая төгрөгийн 15 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажилласан байна.

3.2 ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтийн явцыг холбогдох заавар, журмын дагуу сум, аймгийн тайланг нэгтгэж, Сангийн яамд тайланг хүргүүлсэн байна.

3.2.1. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн арга хэмжээг журам, зааврын дагуу тайлагнасан байна.

Сумдаас 2021 оны ОНХС-гийн хөрөнгөөр хийсэн ажлын тайланг хуулийн хугацаанд аймгийн ХБТХОХ-т ирүүлсэн байна.

Аймгийн ХБТХОХ нь сумдын ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн дүгнэлт өгч, цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний саналыг боловсруулан аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн гэх боловч тодорхой шийдвэр гарсан эсэх тодорхойгүй, аудитын явцад холбогдох материалыг ирүүлээгүй. Харин Сангийн яаманд зөвхөн сумдын ОНХС-гийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайлангийн нэгтгэлийг хүргүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.9⁴¹, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.3⁴², 9.9⁴³ заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Цаашид аймгийн ХБТХОХ нь сумдын ОНХС-гийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн дүгнэлт өгч, цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай асуудлаар аймгийн Засаг даргын шийдвэр гаргуулан Сангийн яаманд хүргүүлэх тухай зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

3.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон 114.2 сая төгрөгийн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд дутуу бүртгэсэн байна.

Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын ажлыг АИТХ-ын тогтоол, сумдын ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтыг ажлыг сумдын Засаг даргын захирамжаар ашиглагч болон захиалагч байгууллагад бүртгүүлэхдээ нийт 114.2 сая төгрөгийн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд дутуу тусгасан зөрчил илэрсэн. Тухайлбал:

1. Шивээговь сумын ОНХС-гийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар тус сумын Засаг даргын 2021 оны 12 дугаарын сарын 30-ны өдрийн А/220 тоот захирамжийг зөрчин сумын

³⁹9.4 Санхүүжилтийн гүйцэтгэлийг тухайн төсөл, арга хэмжээний зураг төсөл болон төсвийн дагуу барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг үндэслэн барилга угсралтын гэрээнд тусгасан үе шатны ажил тус бүрээр гаргаж магадлалаар баталгаажсан зураг төсөл болон төсөвтэй тулгаж, хянан баталгаажуулна.

⁴⁰ 15.3 Захиалагч нь барилга байгууламжийн ажлын үе шат бүрт зохиогчоор хяналт тавиулж, дүгнэлт гаргуулна.

⁴¹ 14.2.9.хөрөнгө оруулалтын арга хэмжээ хэрэгжиж дууссаны дараа хөрөнгө оруулалтын үр дүнгийн талаарх тайланг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх

⁴² 9.3.Аймаг, нийслэлийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг сум, дүүрэг тус бүрээр гарган, дүгнэлт өгч, цаашид даруй авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний саналыг боловсруулан аймаг, нийслэлийн Засаг даргад танилцуулж, холбогдох асуудлаар тодорхой шийдвэрийг гаргуулна.

⁴³ 9.9.Аймаг, нийслэлийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг нэгтгэж, жил бүрийн 3 дугаар сарын 10-ны өдрийн дотор Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ОНХС-ийн асуудал хариуцсан нэгжид ирүүлэх бөгөөд тайланд дараах мэдээллийг тусгана

ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлсэн ажлын 64.6 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй зөрчил илэрснийг албан шаардлага өгч зөрчлийг арилгуулсан байна.

2. Сүмбэр сумын ОНХС-гаар хийгдсэн ажлыг бүртгэлд тусгуулах тухай тус сумын Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 30-ны А/249 дугаартай захирамжид нийт 49.6 сая төгрөгийн хөрөнгийг тусгаагүй байна. Өөрөөр хэлбэл Сүмбэр сумын ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлсэн 42.2 сая төгрөгийн “Нийтийн эзэмшлийн орон сууцнуудын хаалгыг кодтой хаалгаар солих” ажлын хүрээнд бий болсон хөрөнгө, 7.4 сая төгрөгийн 3 зураг төсвийг данс бүртгэлд тусгах шийдвэр гараагүй учраас захиалагч болон ашиглагч байгууллагуудын жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгагдаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4⁴⁴, Нягтлан бодох бүртгэлийн тухай 14 дүгээр зүйлийн 14.4.2⁴⁵, 20 дугаар зүйлийн 20.2.6⁴⁶ заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөтөлбөр, төсөл арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгуулах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

3.2.3. Удирдлагын мэдээллийн системд сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнгийн талаарх мэдээллийг бүрэн оруулаагүй, иргэдийг ил тод нээлттэй мэдээллээр хангаж ажиллаагүй байна.

Удирдлагын мэдээллийн нэгдсэн систем нь хуваарилалт, төлөвлөлт, хэрэгжилт, хяналтын мэдээлэл оруулах 4 үндсэн хэсэгтэй бөгөөд Баянтал сумын ОНХС хуваарилалт, төлөвлөлт, хэрэгжилтийн хэсэгт холбогдох мэдээллийг бүрэн оруулсан байна.

Харин бусад сангууд хэрэгжилтийн хэсэгт нийт 1,574.0 сая төгрөгийн 79 ажлын мэдээллийг оруулаагүй байна.

УМС-д холбогдох мэдээллийг бүрэн байршуулаагүй зөрчлийг дүрслэлээр харуулбал:

Дүрслэл №9

УМС-ийн хуваарилалтын хэсэгт

- Аймгийн Санхүү, Төрийн сангийн хэлтэс нь аймаг, сумдын ОНХС-гийн батлагдсан төсөв, сар, улирлын хуваарийг тус тус оруулаагүй
- Аймгийн ХБТХОХ-ээс АОНХС, Сүмбэр сумын ОНХС нь батлагдсан төсвийг оруулсан боловч тодотгосон төсвийг мэдээлээгүй

Төлөвлөлтийн хэсэгт

- Аймаг, сумдын ОНХС хариуцсан мэргэжилтэн нь аймаг, сумын ИТХ-ын тогтоолоор батлагдсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, ТАХ-ний жагсаалтыг дутуу оруулсан
- Тодотголоор нэмэгдсэн ажлуудыг оруулаагүй

Хэрэгжилтийн хэсэгт

- Аймгийн ОНХС-гаар хийгдсэн 38 хөрөнгө оруулалт, хөтөлбөр, ТАХ-ний хэрэгжилт
- Сүмбэр сумын ОНХС-гаар хийгдсэн 17 хөрөнгө оруулалт, хөтөлбөр, ТАХ-нээс 11
- Баянтал сумын ОНХС-гаар хийгдсэн 9 хөрөнгө оруулалт, хөтөлбөр, ТАХ-нээс 2
- Шивээговь сумын ОНХС-гаар хийгдсэн 28 хөрөнгө оруулалт, хөтөлбөр, ТАХ-ний хэрэгжилтийг тус тус мэдээлээгүй

⁴⁴ 5.1.4.ил тод байдлыг хангасан байх

⁴⁵ 14.4.2.бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага

⁴⁶ 20.2.6.эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3⁴⁷, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 10 дугаар зүйлийн 10.2.2⁴⁸, 10.2.3⁴⁹, 10.2.4⁵⁰ 10.3.2⁵¹, 10.3.3⁵² заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд сангийн хуваарилалт, төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналт, хяналт, бүртгэлийн холбогдох мэдээллийг Удирдлагын мэдээллийн системд бүрэн оруулах, иргэдийг ил тод нээлттэй мэдээллээр хангаж ажиллах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

3.2.4. ОНХС-гийн хөрөнгийн зарцуулалтыг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд дутуу болон хугацаа хоцроож мэдээлсэн байна.

2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар аймаг, сумдын ОНХС-гийн шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хосолсон аудит хийсэн бөгөөд уг аудитаар илэрсэн (Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 151 мэдээллийг ил тод байршуулах) дараах зөрчил дутагдалд албан шаардлага өгч зөрчлийг арилгуулсан байна. Тухайлбал:

1. Сүмбэр сумын ОНХС нь 2.0 сая төгрөгийн 4 мэдээллийг ил тод байршуулаагүй, зарим мэдээлэлд нийлүүлэгчийн нэр хаягийг дутуу мэдээлсэн
2. Шивээговь сумын ОНХС нь 123.9 сая төгрөгийн 24 мэдээллийг ил тод байршуулаагүй, 21 удаагийн мэдээллийг хугацаа хоцроосон
3. Баянтал сумын ОНХС нь 11 мэдээллийн хугацаа хоцроосон

Гүйцэтгэлийн аудитаар нийт 1.215.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, 575.6 сая зөрчилд 7 албан шаардлага, 639.9 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах 13 зөвлөмж өглөө.

⁴⁷ өрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах

⁴⁸ 10.2.2. ОНХС-аас аймаг, нийслэлд шилжүүлэх орлогын шилжүүлгийн сар, улирлын батлагдсан хуваарийг Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ОНХС хариуцсан нэгж жил бүрийн 1 дүгээр сарын 5-ны өдрийн дотор ОНХС-ийн УМС-д оруулна;

⁴⁹ 10.2.3. Аймаг, нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэс нь орон нутгийн төсвийн батлагдсан сар, улирлын хуваарьтай нийцүүлэн ОНХС-ийн дансанд шилжүүлж, ОНХС-ийн УМС-д бүртгэнэ

⁵⁰ 10.2.4. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ОНХС хариуцсан нэгж нь ОНХС-ийн орлогын шилжүүлгийг Төв төрийн сангийн сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ гарсны дараа ажлын 5 хоногийн дотор аймаг, нийслэлийн ОНХС-ийн дансанд шилжүүлж, ОНХС-ийн УМС-д бүртгэнэ

⁵¹ 10.3.2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС хариуцсан мэргэжилтэн ОНХС-ийн УМС-ийн хэрэгжилт цэсэд хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн талаарх мэдээллийг ОНХС-ийн УМС-д оруулж, оруулсан мэдээллийн дагуу санхүүжилтийг хийнэ

⁵² 10.3.3. ОНХС-ийн хуваарилалт, төлөвлөлт болон өмнөх оны хэрэгжилт, тайлан, хяналтын талаарх мэдээллийг ОНХС-ийн УМС-д зохих журмын дагуу оруулаагүй бол тухайн зөрчлийг арилгах хүртэл ОНХС, аймаг, нийслэлийн ОНХС-аас орлогын шилжүүлэг олгохгүй

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

Бүлэг-1 Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтөд иргэдийн оролцоо хангалтгүй байна.

1.1 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн эх үүсвэрийг хууль, журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлсэн боловч санхүүжилтийг төсвийн хуваарийн дагуу олгоогүй байна.

1.2 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээг орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан төлөвлөсөн боловч иргэдийн саналыг хүртээмжтэй байдлаар аваагүй, санал авч эрэмбэлээгүй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг баталсан байна.

Бүлэг-2 ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь орон нутгийн хөгжилд бодит үр дүнгээ үзүүлж байгаа боловч нийтийн эзэмшлийн хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт хангалтгүй байна.

2.1 Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөтөлбөр, төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхдээ худалдан авах ажиллагааг журмын дагуу зохион байгуулсан боловч сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

2.2. Ажлын хэсгүүд ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний төлөвлөсөн зорилтот түвшин, үр ашиг, үр дүнг бодитой тодорхойлоогүй боловч орон нутгийн хөгжилд бодит үр дүнг үзүүлж байна.

2.3 ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон нийтийн эзэмшлийн хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт хангалтгүй байна.

Бүлэг-3 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн ажилд явцын хяналт хийгдээгүй байна.

3.1 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба, АИТХ, сумдын ИТХ-ын дэргэдэх хороо нь хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.2 ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтийн явцыг холбогдох заавар, журмын дагуу сум, аймгийн тайланг нэгтгэж, Сангийн яамд тайланг хүргүүлсэн байна.

ЗӨВЛӨМЖ

Аймаг, сумдын ИТХ-д

1. Аймаг, сумдын ИТХ чиг үүргийн дагуу ОНХС-гийн үйл ажиллагаанд хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх
2. Иргэдээс санал аваагүй, эрэмбэлсэн жагсаалтад ороогүй төсөл, арга хэмжээг батлахгүй байх

Аймаг, сумдын Засаг дарга нарт

1. ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлэх ажилд санал авахдаа иргэдийн оролцоог нэмэгдүүлэх
2. Иргэдээс санал аваагүй, эрэмбэлсэн жагсаалтад ороогүй төсөл, арга хэмжээг төлөвлөж, батлуулахгүй байх
3. ОНХС-аас тухайн шатны Засаг даргын чиг үүрэгт хамаарах төсөл, арга хэмжээг төлөвлөж, батлуулахгүй байх
4. Ажлын хэсэг томилсон шийдвэрийн хэрэгжилтийг хангуулж, ажлын хэсгийн үйл ажиллагаанд хяналт тавих
5. Зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалтыг хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулах
6. Ажлын хэсэг урьдчилан тооцсон төсөвт өртгийг үр өгөөж хүртэгчдийн тоонд харьцуулах замаар үр ашгийн тооцоолол хийх
7. Аймаг, сумдын ОНХС-гийн төлөвлөлт, хэрэгжилтэд хяналт тавих, хяналт шалгалтыг үр дүнтэй хэрэгжүүлэх
8. ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөтөлбөр, төсөл арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгуулах
9. Сангийн хуваарилалт, төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналт, хяналт, бүртгэлийн холбогдох мэдээллийг Удирдлагын мэдээллийн системд бүрэн оруулах, иргэдийг ил тод нээлттэй мэдээллээр хангаж ажиллах

Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанд

1. ОНХС-гийн үйл ажиллагаанд журмын дагуу хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлж, тайлагнах

Аймгийн Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс

1. Сумдын ОНХС-гийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн дүгнэлт өгч, цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай асуудлаар аймгийн Засаг даргын шийдвэр гаргуулан Сангийн яаманд хүргүүлэх

ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг,
Найрамдал хотхон, Утас/Факс: (976) 7054 3005,
И-мэйл: zdtg.gsa@gmail.com, Вэбсайт: www.govisumber.gov.mn

2022.06.13

№

A/967

танай

-ны


№

-т

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Орон нутгийн хөгжлийн сангийн 2021 оны
бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүнд дүнд
хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлд
тусгах санал байхгүй болно.


Г.БАТЗАМ


Ана У.Батбаяр хануу
Саналыг тусгах
тайлангаас барагцаа-
нууруулаа
Анхд
13/13



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
СҮМБЭР СУМЫН ЗАСАГ ДАРГА

42017 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, Чойр.
Утас: 7054 3249, И-мэйл: gsasumber@gmail.com

2022.06.13 № А/532
танай 2022.06.10 -ны № 197 -т

АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Сүмбэр сумын “Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн”-д хийсэн аудит дүгнэлтэд саналгүй болно.



Т.БАТ-ЭРДЭНЭ

На У.Батмөнхэнд
Саналгүй тусал
төрийн баримтаа-
нууцах

Бүх
11/13

425220240



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГА

42040 Говьсүмбэр аймаг, Баянтал сум, Лүн,
Утас: 9411 3190, <http://www.bayantal.gs.gov.mn>

2022.06.13 № 175

танай 2022.06.10ны № 127 -т

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

“Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт,
зарцуулалт, үр нөлөө, үр дүнд-д” хийсэн Гүйцэтгэлийн
аудитын тайлангийн төсөлтэй танилцсан санал, хүсэлт
байхгүй болно.

ДАРГА



Г.АНХБАЯР

На Н.Батсодхон
Сансарт тууган
тайланг баталмаа
нуурух

11/13

421220225



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГА

42030 Говьсүмбэр аймаг, Шивээговь сум,
Утас: 7054 6426, И-мэйл: shiweegovi.zdtg@gmail.com

2022.06.13 № 2/299
танай _____-ны № _____-т

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.САРАНТУЯА
ТАНАА

Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн
бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүнд хийсэн
гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй
танилцсан санал хүсэлт байхгүй болно.

Хавсралт 1 хуудастай

ОРЛОГЧ ДАРГА



Ч.СУГАРМАА

Ага В. Барсболд
Салбарын тусгай
тасаагаа баталгаа
нууцлох

C:\Documents\B-H\TOOT.doc

42522 331

11/13

ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР

Тайлангийн төсөлтэй танилцаад шалгагдагч байгууллагуудаас ирүүлсэн санал байхгүй байна.